



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/222-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 70362442 Цахим хаяг: baasansurens@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15-16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16-17
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8. Аудитын гол асуудал.....	18
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11. Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	18-20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.18 № СЭА-2022/222-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,741,215.00	3,170,488.31
33	АВЛАГА	-	67,273.31
33500	Бусад авлага	-	67,273.31
33510	Байгууллагаас авах авлага	-	67,273.31
35	БАРАА МАТЕРИАЛ	2,741,215.00	3,103,215.00
35100	Түүхий эд материал	-	110,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	110,000.00
35400	Хангамжийн материал	2,741,215.00	2,993,215.00
35420	Аж ахуйн материал	2,741,215.00	2,993,215.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,870,497.24	42,195,295.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,870,497.24	42,195,295.76
39200	Биет хөрөнгө	43,870,497.24	42,195,295.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,000,000.00	37,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,000,000.00)	(37,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	60,885,797.76	71,027,303.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,272,400.53)	(31,635,407.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,692,154.00	8,692,154.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,435,053.99)	(5,888,754.00)
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	46,611,712.24	45,365,784.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	46,611,712.24	45,365,784.07
51	Засгийн газрын хувь оролцоо	46,611,712.24	45,365,784.07
51200	Хуримтлагдсан үр дүн	46,611,712.24	45,365,784.07
51210	Өмнөх үеийн үр дүн	11,513,269.95	46,611,712.24
51220	Тайлант үеийн үр дүн	35,098,442.29	(1,245,928.17)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	46,611,712.24	45,365,784.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	381,311,683.00	248,601,783.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,593,371.00	10,251,505.68
120	Нийтлэг татварын бус орлого	19,309,390.00	10,251,505.68
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	19,309,390.00	10,251,505.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,742,000.00	2,353,934.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,567,390.00	10,251,505.68
122	Тусламжийн орлого	20,283,981.00	
122001	Хандив тусламж /дотоод/	20,283,981.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	341,718,312.00	238,350,278.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	108,907,500.00	112,386,400.00
122005	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	108,907,500.00	112,386,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	232,810,812.00	125,825,855.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс хуваарилсан	2,324,080.00	9,305,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230,486,732.00	114,166,121.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	346,121,506.46	249,847,711.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,121,506.46	249,847,711.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,049,028.18	249,102,503.45
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	128,060,889.17	100,906,392.94
210101	Цалин	108,302,532.17	69,166,137.92
210102	Нэмэгдэл цалин	12,004,448.00	20,748,206.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,078,858.00	3,927,530.14
210104	Урамшуулал	4,675,051.00	7,064,518.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,148,761.25	13,168,452.35
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,099,885.65	9,466,166.74
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,305,868.90	896,531.23
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,024,535.12	806,338.36
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	247,133.78	195,940.48
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,471,337.80	1,803,475.54
2104	Хангамж, бараа материалын зардал	3,829,400.00	4,266,800.00
210401	Бичиг хэргийн материал	2,330,200.00	2,800,696.00
210402	Тээвэр, шатахууны зардал	845,000.00	718,200.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	619,400.00	515,104.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	34,800.00	232,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,110,000.00
210604	Урсгал засвар	-	3,110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	193,356,283.30	111,432,651.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	192,178,083.30	109,766,351.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	247,500.00	247,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	807,500.00	1,295,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,653,694.46	16,218,207.16
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	167,400.00	4,401,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,486,294.46	11,816,707.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,072,478.28	745,208.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	305,000.00	244,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	305,000.00	244,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	767,478.28	501,208.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	767,478.28	501,208.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	35,190,176.54	(1,245,928.17)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	91,734.25	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	91,734.25	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(91,734.25)	
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	35,098,442.29	(1,245,928.17)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	343,460,312.00	238,350,278.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,460,312.00	238,350,278.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	108,907,500.00	112,386,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	108,907,500.00	112,386,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	234,552,812.00	125,825,855.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,324,080.00	9,305,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230,486,732.00	114,166,121.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,742,000.00	2,353,934.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	138,023.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	138,023.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	338,695,012.00	238,350,278.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338,695,012.00	238,350,278.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,622,533.72	237,605,069.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,915,424.64	95,804,893.89
210101	Үндсэн цалин	72,157,067.64	62,466,588.87
210102	Нэмэгдэл	12,004,448.00	22,005,756.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,078,858.00	3,927,530.14
210104	Урамшуулал	4,675,051.00	7,405,018.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,661,497.08	12,501,054.71
210201	Тэтгэврийн даатгал	10,197,304.52	8,728,130.79
210202	Тэтгэмжийн даатгал	375,497.64	974,501.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	290,319.71	762,801.26
210204	Ажилгүйдлийн даатгал	72,578.93	185,056.54
210205	Эрүүл мэндийн даатгал	725,796.28	1,850,564.40
2104	Хангамж, бараа материалын зардал	4,211,800.00	4,474,800.00
210401	Бичиг хэрэг	2,283,400.00	2,789,300.00
210402	Тээвэр, шатахуун	845,000.00	718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	619,400.00	526,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	464,000.00	440,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,000.00	3,124,000.00
210604	Урсгал засвар	124,000.00	3,124,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,082,232.00	117,298,821.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,904,032.00	115,582,521.00

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	247,500.00	247,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	807,500.00	1,345,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,627,580.00	4,401,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,324,080.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,500.00	4,401,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,072,478.28	745,208.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	305,000.00	244,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	305,000.00	244,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	767,478.28	501,208.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	767,478.28	501,208.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,765,300.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,765,300.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,765,300.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	4,765,300.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,765,300.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,765,300.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	11,513,269.95	11,513,269.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	11,513,269.95	11,513,269.95
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	35,098,442.29	35,098,442.29
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	46,611,712.24	46,611,712.24
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	46,611,712.24	46,611,712.24
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	46,611,712.24	46,611,712.24
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,245,928.17)	(1,245,928.17)
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	45,365,784.07	45,365,784.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	112,386,400.00	111,929,125.00	457,274.40	99.6%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	112,386,400.00	111,929,125.00	457,274.40	99.6%
210	Бараа, үйлчилгээний зардал	112,142,400.00	111,685,125.60	457,274.40	99.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,375,500.00	95,326,370.89	49,129.11	99.9%
210101	Үндсэн цалин	66,432,000.00	62,328,565.87	4,103,434.13	93.8%
210102	Нэмэгдэл	18,524,400.00	22,005,756.20	(3,481,356.20)	118.8%
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	5,342,400.00	3,927,530.14	1,414,869.86	73.5%
210104	Урамшуулал	5,076,700.00	7,064,518.68	(1,987,818.68)	139.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,875,800.00	12,501,054.71	374,745.29	97.1%
210201	Тэтгэврийн даатгал	9,060,700.00	8,728,130.79	332,569.21	96.3%
210202	Тэтгэмжийн даатгал	953,800.00	974,501.72	(20,701.72)	102.2%
210203	ҮОМШӨ ний даатгал	763,000.00	762,801.26	198.74	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	190,800.00	185,056.54	5,743.46	97.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,907,500.00	1,850,564.40	56,935.60	97.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	2,199,800.00	2,199,800.00	-	100.0%
210401	Бичиг хэрэг	514,300.00	514,300.00	-	100.0%
210402	Тээвэр (шатахуун)	718,200.00	718,200.00	-	100.0%
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	526,500.00	526,500.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	440,800.00	440,800.00	-	100.0%
2106	Эд хогшил худалдан авах	124,000.00	124,000.00	-	100.0%
210604	Урсгал засвар	124,000.00	124,000.00	-	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,263,800.00	1,230,400.00	33,400.00	97.4%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,100.00	146,100.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	247,500.00	247,500.00	-	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00	-	100.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,300.00	44,000.00	20,300.00	68.4%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	726,700.00	713,600.00	13,100.00	98.2%
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	303,500.00	303,500.00	-	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,500.00	303,500.00	-	100.0%
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,000.00	244,000.00	-	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	244,000.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	244,000.00	244,000.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	112,386,400.00	111,929,125.00	457,274.40	99.6%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	112,386,400.00	111,929,125.00	457,274.40	99.6%
122005	Улсын төсвөөс санхүүжих	112,386,400.00	111,929,125.00	457,274.40	99.6%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1	1	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	7	7	-
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	234,552,812.00	125,825,855.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	234,552,812.00	125,825,855.00
210	Бараа, үйлчилгээний зардал	234,552,812.00	125,781,921.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	340,500.00
210104	Урамшуулал	-	340,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,742,000.00	2,275,000.00
210401	Бичиг хэрэг	1,742,000.00	2,275,000.00
2106	Эд хогшил худалдан авах	-	3,000,000.00
210604	Урсгал засвар	-	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	232,810,812.00	116,068,421.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,810,812.00	115,436,421.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	632,000.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,098,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,098,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	43,934.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	43,934.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	43,934.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	234,552,812.00	125,825,855.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,742,000.00	2,353,934.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,742,000.00	2,353,934.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	232,810,812.00	123,471,921.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,324,080.00	9,305,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230,486,732.00	114,166,121.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс / цаашид Статистикийн хэлтэс гэх /-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг бүрэн гүйцэт хөтлөх, жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтаар хөтлөх, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлэх зэрэг анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Статистикийн хэлтэс нь “Монгол Улсын статистик мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг “Албан ёсны статистикийн бүртгэл хөтлөх, мэдээлэл гаргаж өгөх, дамжуулах, нэгтгэн боловсруулах, тооллого, судалгаа явуулах, дүгнэлт гаргах, мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тархаах, хэвлэн нийтлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, сан байгуулах, хадгалах статистикийн бүх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахад чиглэгдэнэ.” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд сангийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Статистикийн хэлтсийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд ҮСХ-ны Дотоод аудит, мониторингийн хэлтсээс “Худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилт”-д дотоод хяналт шалгалт хийж, зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 346,121.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,191.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 4,153.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,245.9 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		67.3	67.3
Урьдчилгаа			
Бараа материал	2,741.2	3,103.2	362.0
Үндсэн хөрөнгө	43,870.5	42,195.3	(1,675.2)
Нийт хөрөнгө	46,611.7	45,365.8	(1,245.9)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	46,611.7	45,365.8	(1,245.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	46,611.7	45,365.8	(1,245.9)

Авлагын данс 67.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь НДШ-ийг илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,103.2 мянган төгрөг болж 362.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн санхүүжилтээр нийт 35,495.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ҮСХ-ноос 110.0 мянган төгрөгийн бусад хангамжийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, нийт 35,243.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 117,169.4 мянган төгрөг болж өмнөх оноос 10,141.5 мянган төгрөгөөр өссөн нь ҮСХ-ноос 3 ширхэг суурин компьютерыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 45,365.8 мянган төгрөг болж 1,245.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого нь өмнөх оноос 132,847.9 мянган төгрөгөөр буюу 34.8 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хандив тусламжийн орлого буурснаас голлон шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь өмнөх оноос 96,547.3 мянган төгрөгөөр буюу 27.9 хувиар буурсан нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардал /Өмнөх онд 10 жил тутам зохион байгуулагддаг хүн амын

тооллоготой холбоотой өндөр зардал гарсан байсан./ 82,411.8 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Статистикийн хэлтсийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 191,615.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 78,780.5 мянган төгрөгөөр бууруулж, 112,834.7 мянган төгрөгөөр баталсан бол 2021 оны 12 дугаар сард батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, 448.3 мянган төгрөгөөр бууруулан, **112,386.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 112,386.4 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 112,386.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт урсгал зардалд **111,929.2** мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 457.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 111,929.1 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 49.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 374.7 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн оношилгооны зардал 20.3 мянган төгрөг, улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардал 13.1 мянган төгрөг зэрэг нийт **457.2** мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ҮСХ-ноос 114,166.1 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 9,305.8 мянган төгрөг, “Статистикийн эмхэтгэл” борлуулсны 2,353.9 мянган төгрөг зэрэг нийт **125,825.8** мянган төгрөгийн орлого бүрдүүлж, дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Хагас жилийн мал тооллогын цалин, урамшууллын зардалд 11,331.2 мянган төгрөг, шатахууны зардалд 723.8 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 375.0

мянган төгрөг, томилолтын зардалд 361.8 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 227.0 мянган төгрөг зэрэг нийт **13,018.8** мянган төгрөгийг,


- Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын цалин, урамшууллын зардалд 10,409.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 829.3 мянган төгрөг, шатахууны зардалд 789.6 мянган төгрөг, шуудан холбооны зардалд **442.0** мянган төгрөг, бусад зардалд 560.0 мянган төгрөг зэрэг нийт **13,029.9** мянган төгрөгийг,
- Өрх, нийгэм эдийн засаг болон ажиллах хүчний судалгааны цалин, урамшууллын зардалд 45,607.5 мянган төгрөг, шатахууны зардалд 10,894.2 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 43.5 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 2,120.0 мянган төгрөг зэрэг нийт **58,665.2** мянган төгрөгийг,
- Бичил уурхай эрхлэгчдийн болон бусад 15 төрөл / *Аж үйлдвэрийн, барилгын салбарын, зочид буудал-зоогийн газрын, мэдээлэл-холбооны, тээврийн, эрүүл мэндийн салбарын үнийн болон тогтвортой хөгжлийн үзүүлэлт, бизнесийн түүвэр, хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлтийн I* -ийн судалгааны цалин, урамшууллын зардалд 19,084.6 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 3,129.6 мянган төгрөг, шатахууны зардалд 2,180.9 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,757.2 мянган төгрөг, бусад зардалд 3,141.5 мянган төгрөг зэрэг нийт **29,293.8** мянган төгрөгийг,
- Авто тээврийн хэрэгслийн урсгал зардалд 3,000.0 мянган төгрөг, маягт хэвлүүлэх зардалд 632.0 мянган төгрөг зэрэг нийт **3,632.0** мянган төгрөгийг,
- Аймгийн 90 жилийн ойд зориулан “Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн эмхэтгэл” хэвлүүлэх зардалд 3,500.0 мянган төгрөг, мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын шатахууны зардалд 2,332.2 мянган төгрөг, сар бүр гаргадаг “Статистикийн эмхэтгэл”-ийг хэвлэх цаасны зардалд 2,310.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, хэмнэлтийн 43.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Тайлант онд тус хэлтэс нь “*Бизнесийн түүвэр судалгаа*”, “*Тогтвортой хөгжлийн үзүүлэлтийн судалгаа*”, “*Өртгийн зэрэгцүүлэх үнийн судалгаа*”, “*Хүүхдийн албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа*” зэрэг судалгаануудыг шинээр хийж эхэлсэн байна.

3.7.2 Мөн 10 жил тутам зохион байгуулагддаг аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг “Тооллого.1212.mn” цахим системээр анх удаа явуулсан байна.

3.7.3 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 37,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 2 нэр төрөл /*Тээврийн хэрэгсэл*/ -ийн хөрөнгийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.



3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Статистикийн хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 140 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Статистикийн хэлтсийн тайлант оны үйл ажиллагаанд 112,386.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 111,929.2 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.4 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **7,117.9** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 3,138.1 мянган төгрөгийн алдааг залруулж,

3,979.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд нийгмийн даатгалын сангаас олгосон 138.1 мянган төгрөгийн ХЧТА-ны тэтгэмжийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасныг залруулга хийлгэв.
- Нэмэлт санхүүжилтийн данснаас СЭА 29-89 улсын дугаар бүхий Nilux маркийн авто машины засвар, сэлбэг хэрэгсэлд НМХМ ХХК-д 1,348.0 мянган төгрөг, Хангайн өндөр уул ХХК-д 737.0 мянган төгрөг, Хүүхдийн мөрт ХХК-д 250.0 мянган төгрөг, иргэн Мөнхбаатарын харилцах дансанд 460.0, иргэн Энхцэцэгийн харилцах дансанд 205.0 мянган төгрөг зэрэг нийт **3,000.0** мянган төгрөгийг шилжүүлж, засвар үйлчилгээ хийснийг “Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг”-т нөхөж бичүүлэв.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-т нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлыг агуулга тус бүрээр бус аймгийн Онцгой комиссын тандалт судалгааны багт ажилласан гэх үндэслэлээр илүү цагийн хөлсөнд нийт 3,979.8 мянган төгрөгийг олгосон байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.4 дэх “Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл бүрээр бичнэ.” гэсэн заалтыг зөрчсөн тул цаашид “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-т нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг хийж гүйцэтгэсэн ажил тус бүрээр бичиж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтаар хөтлөөгүй, ирсэн, явсан хугацааг бүртгэж, шатахуун зарцуулсан албан хаагчийн гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг

хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг тус тус зөрчсөн тул цаашид батлагдсан жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж, холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	5	7,117.9	2	3,138.1					3	3,979.8